

ЕГИПЕТ:

МБРАХИМ ЭЗ ЭЛЬ-ДИН

КАИР ХОТЫН ГУДАМЖНААС ОР СУРАГГУЙ БОЛЖЭЭ

ЭРХИЙНХЭЭ
ТӨЛӨӨ
БИЧИЦГЭЭЭ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНИЛ



ИБРАХИМ ЭЗ ЭЛЬ-ДИН

ЕГИПЕТ

Ибрахим Эз Эль-Дин нь Египетийн Каир хотод амьдардаг 26 настай хүний эрхийн судлаач юм. Тэрээр хүний үндсэн эрхүүдийн нэг болох аюулгүй, шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийн асуудлаар судалгаа хийж, тайлагнадаг ажилдаа чин сэтгэлээсээ дуртай нэгэн байв. Ажлаас гадуур Ибрахим зурах дуртай, загвар, дизайны урлаг сонирхдог, хөл бөмбөгийн хорхойтон, нутгийн баг болох Замалек Спорт Клубыг цаг ямагт дэмжиж иржээ.

2019 оны 6-р сарын 11-ний орой Ибрахимыг гэр рүүгээ харьж явахад нь энгийн хувцастай аюулгүйн албаны дөрвөн ажилтан бүслэн авч, баривчилжээ. Түүнийг баривчилсныг мэдсэн даруйдаа ээж нь цагдаагийн хэлтэст очсон ч цагдаа Ибрахимыг байхгүй хэмээн бүр хоригдсон гэдгийг нь ч үгүйсгэжээ. Тэр өдрөөс хойш Ибрахимын гэр бүл түүнд юу тохиолдсоныг хаана байгааг нь олж мэдэж чадаагүй л байна.

Хүний эрх, эрх чөлөөний төлөөх Египетийн Комисс байгууллагаас гурван жилийн дотор таван хүн баривчлагдсаны тав дахь нь Ибрахим байсан юм. Ибрахимын адил олон зуун хүн шүүхээр оролгүйгээр хэдэн сар хүчээр ор сураггүй алга болж байна. Сэтгүүлчдээс эхлэн хөл бөмбөгийн дэмжигч, бүр улс төрчид хүртэл тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх, эрх баригчдыг шүүмжлэх буюу хүний эрхийг хамгаалахаар тэмцсэнийхээ төлөө баривчлагдаж байна.

ЕГИПЕТИЙН ЭРХ БАРИГЧ НАРТ ХАНДАН ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭ

Ибрахимын байгаа газрыг илчилж, гэр бүл, өмгөөлөгчтэй нь уулзуулах, түүнийг эрүү шүүлтэд өртөхөөс хамгаалахыг шаардацгаая. Олон улсад гэмт хэрэгт тооцогдох хэрэгт холбогдоогүй л бол түүнийг суллах ёстойг сануулцгаая.

Public Prosecutor Nabil Sadek
Office of the Public Prosecutor
Madinat al-Rehab
Cairo, Arab Republic of Egypt
Fax: +20 225 774 716
Salutation: Dear Sir

ИБРАХИМЫН ГЭР БҮЛД ЭВ САНААНЫ НЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ.

Ибрахимд юу тохиолдсоныг олж мэдэх итгэл найдварыг өгөх чин сэтгэлийн захидал зурвас илгээгээрэй.

The family of Ibrahim Ezz El-Din

C/o: The Egyptian Commission for Rights and Freedoms
4A, Al-Saraya al kobra,
Garden City – Cairo, Egypt

**ЗАХИДАЛ БИЧИЖ
ӨВӨРЧЛӨЛТ ХИЙЦГЭЭ**

December 2019
Index: MDE 12/0909/2019 English
Images: Cover: © Private (Main image),
© Dan/CC BY-SA
Back page: © Private